



УУХҮЯ, АМГТГ



ШУТИС, ГУУС, ГТССМТ



МГТИН

## Газрын тосны Зөвлөх, Мэргэшсэн инженерийн сургалт

Уул уурхайн сайдын 2015-3-12-ны 53-р тушаалаар Монгол улсын Газрын тосны салбарын инженерүүдэд мэргэжлийн зэрэг олгох, түүнийг төрийн эрх бүхий байгууллагаас баталгаажуулж, хяналт тавихтай холбогдсон харилцааг зохицуулах журмыг([www.mm.gov.mn](http://www.mm.gov.mn), [www.must.edu.mn](http://www.must.edu.mn), [www.mspe.mn](http://www.mspe.mn)) баталсан болно.

Газрын тос, уламжлалт бус газрын тосны инженерүүдийн мэргэжлийн мэдлэг, мэргэшлийн ур чадвар, түвшин, өрсөлдөх чадварыг дээшлүүлэх, бүтээл, туршлагыг үнэлэх, тэдний ажил үйлчилгээний чанарыг сайжруулахад энэ журмын зорилго оршиж байгаа юм.

Газрын тосны Мэргэшсэн, Зөвлөх инженерийн сургалт явуулах, зэрэг дэв олгох, сунгах, түдгэлзүүлэх, бууруулах, цуцлах, хүчингүй болгох харилцааг энэхүү журмаар зохицуулах бөгөөд уг ажлыг удирдан хэрэгжүүлэх Зөвлөлийг УУХҮЯ болон ШУТИС-д, Зөвлөлийн ажлын албаны чиг үүргийг хэрэгжүүлэх, шалгаруулалт хийх, сургалт явуулах, зэрэг дэв олгох үйл ажиллагааг гардан хариуцах “Газрын тосны сургалт, судалгаа, мэдээллийн төв”-ийг ШУТИС-ийн ГУУС-ийн Газрын тосны инженерийн салбарт түшиглэн байгуулсан болно.

Энэ бүхэн нь Газрын тосны салбарын Мэргэшсэн, Зөвлөх инженерийн сургалтыг явуулах, зэрэг дэв олгох эрх зүй, нөхцлийг бүрэлдүүлсэн юм. Энэ удаагийн сургалтыг **2017 оны 06 сарын 5-наас 06 сарын 23-ны өдөр** хүртэл ШУТИС-ийн ГУУС-ийн Газрын тосны сургалт-судалгаа-мэдээллийн төв дээр явагдах болсныг зарлан сонордуулж, холбогдох болзлыг хангасан хүмүүсийг хамрагдахыг урьж байна.

**Бүртгэл эхлэх хугацаа: 2017-05-22-нээс 2017-05-30.** ШУТИС-ийн хичээлийн I байр 310 тоот

**Тавигдах шаардлага:** Бакалавр бол мэргэжлээрээ тасралтгүй 8-аас доошгүй, магистр бол 5-аас доошгүй жил ажиллаж туршлагажсан, зохих бүтээл, нийтлэл, туурвилтай байх.

**Бүрдүүлэх материал:** Зэрэг горилохыг хүссэн хувийн өргөдөл, иргэний үнэмлэхийн хуулбар-2%, анкет, 3х4 зураг-2% , ажил байдлын тодорхойлолт, дипломын баталгаажуулсан хуулбар, мэргэжил дээшлүүлсэн талаархи үнэмлэх, гэрчилгээ бусад баримтуудын хуулбар, бүтээлийн жагсаалт, сургалтын төлбөр нь зөвлөх зэрэг горилогчийнх-1 сая төгрөг, мэргэшсэн зэрэг горилогчийнх-800 мян.төг. ШУТИС-ГУУС Голомт банк 8115007020 тоот дансанд тушаасан баримт.

**Газрын тосны мэргэжлийн Эрхэм инженерүүд та бүхнийг эзэмшсэн мэргэжил, бүтээл туурвилаа баталгаажуулж, зэрэг дэвээ ахиулах энэхүү сургалтанд урьж байна.**

Газрын тосны Мэргэшсэн, Зөвлөх инженерийн зэрэг дэв олгох Зөвлөл  
ШУТИС-ийн Газрын тосны сургалт, судалгаа, мэдээллийн төв  
Монголын Газрын тосны инженерүүдийн нийгэмлэг

Харилцах утас-99185616-А.Баасанжаргал, 99110575-Ж.Цэвээнжав  
Цахим хаяг-[baaskanil@yahoo.com](mailto:baaskanil@yahoo.com), [btseven2003@yahoo.com](mailto:btseven2003@yahoo.com)